



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны 9, 13, 22 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон “Барилга, хот байгуулалтын яамны шагнал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Тэргүүний барилгачин”, “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт цолны тэмдэг, үнэмлэх, хавтас хийлгэх зардлыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас, “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх, хавтас хийлгэх зардлыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас тус тус гаргаж байхыг холбогдох байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Баярсайхан/-т үүрэг болгосугай.


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 227 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Б.МӨНХБААТАР

152210058

Барилга, хот байгуулалтын сайдын
2025 оны 01 сарын 26 өдрийн
21 дугаар тушаалын хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ХҮНДЭТ ТЭМДЭГ БОЛОН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон Барилга, хот байгуулалтын яамны шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох, олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон Барилга, хот байгуулалтын яамны шагналын зорилго нь Монгол Улсын барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц, газрын харилцааны салбарын ажилтнуудын хөдөлмөр зүтгэл, гаргасан ололт амжилт, үр бүтээлийг үнэлэх, тэдний идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, сайшаан урамшуулахад оршино.

1.3. Шагналыг олгохдоо тус салбарын ажилтны ажлын ололт амжилт, үр бүтээл, тус салбарт ажилласан хугацааг гол шалгуур болгохын зэрэгцээ тухайн ажилтны ажилладаг байгууллагын бүтээн байгуулалт, ажлын үр дүнг харгалзан үзэх зарчмыг баримтална.

Хоёр. Шагналын төрөл

2.1. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон Барилга, хот байгуулалтын яамны шагнал дараах төрөлтэй байна:

2.1.1. “Тэргүүний барилгачин” хүндэт тэмдэг;

2.1.2. “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.3. “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.4. Барилга, хот байгуулалтын яамны “Жуух бичиг”;

2.1.5. Барилга, хот байгуулалтын яамны “Хүндэт дэвтэр”.

Гурав. Шагнал олгох ерөнхий нөхцөл

3.1. Шагналыг яам, Засгийн газар гэсэн дарааллаар дор дурдсан үзүүлэлтийг хангасан албан хаагч, иргэнд олгоно. Үүнд:

3.1.1. Барилга, хот байгуулалтын яамны “Жуух бичиг”-ээр тухайн салбартаа 5-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан яам, агентлаг, харьяа байгууллагын албан

хаагч, хот байгуулалт, төлөвлөлт, архитектур, барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, засвар шинэчлэлт, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн байгууламжийн ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагын ажилтан, албан хаагч, газрын харилцаа, геодези, зураг зүйн ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагын ажилтан, албан хаагч, мэргэжлийн холбоо, ТББ, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан, болон бусад;

3.1.2. “Тэргүүний барилгачин” хүндэт тэмдгээр тухайн салбартаа 15-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан яам, агентлаг, харьяа байгууллагын албан хаагч, хот байгуулалт, төлөвлөлт, архитектур, барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, засвар шинэчлэлт, барилгын материалын үйлдвэрлэл, мэргэжлийн холбоо, ТББ, ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагын ажилтан, албан хаагч, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан, болон бусад;

3.1.3. “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр тухайн салбартаа 15-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан яам, агентлаг, харьяа байгууллагын албан хаагч, орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн байгууламжийн ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагын ажилтан, албан хаагч, мэргэжлийн холбоо, ТББ, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад;

3.1.4. “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр тухайн салбартаа 15-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан яам, агентлаг, харьяа байгууллагын албан хаагч, газрын харилцаа, геодези, зураг зүйн ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагын ажилтан, албан хаагч, мэргэжлийн холбоо, ТББ, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан, болон бусад;

3.1.5. Барилга, хот байгуулалтын яамны “ХҮНДЭТ ДЭВТЭР”-т салбартаа 30-аас доошгүй жил ажиллаж, салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт, үр бүтээл гаргасан удирдах болон ахмад ажилтны алдар гавьяа, сайн үйлс, үлгэр дуурайллыг алдаршуулж, алдар нэрийг нь мөнхжүүлэн бичиж үлдээнэ. Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай гэрчилгээ олгоно. Хүндэт дэвтэрт бичигдэх ажилтан салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан байна.

3.2. Тухайн салбарыг хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт онцгой амжилт, шинэ санаачилга, бүтээл гаргасан, улс орны хэмжээний нээлт хийж, улс нийгэмд тодорхой ашиг тус өгсөн иргэнийг 3.1.1-3.1.4-т заасан хугацааг харгалзахгүйгээр шагнаж болно.

3.3. Шагналыг шатлан ахих журмаар олгох бөгөөд шагнагдсанаас хойш 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт, үр бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлж тодорхойлно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, түүнийг хүлээн авах

4.1. Төрийн албан хаагчийг тухайн байгууллагын удирдлага нэр дэвшүүлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн, тодорхойлно.

4.2. Салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан болон тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг одоо ажиллаж байгаа болон хамгийн сүүлд ажиллаж байсан байгууллага, аж ахуйн нэгж нь шагналд тодорхойлно.

4.3. Аль нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалалгүй ахмад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэн, ахмад настныг оршин сууж буй аймаг, дүүргийн Засаг дарга тодорхойлж болно.

4.4. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод нь гишүүн байгууллагын шагналын хүсэлтийг нэгдсэн журмаар авч саналаа ирүүлнэ.

4.5. Монгол Улсын барилгын салбарын хөгжилд онцгой амжилт гаргаж бодитой дэмжлэг туслалцаа үзүүлсэн гадаадын иргэнийг дээрх шагналаар шагналаар шагнаан урамшуулж болно.

4.6. Шагналд нэр дэвшигчийг тодорхойлохдоо дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

4.6.1. Шагнуулах тухай үндсэн байгууллагын хүсэлт;

4.6.2. Шагналд нэр дэвшигчийн анкет /Маягт 1/;

4.6.3. Байгууллагын удирдах ажилтны баталгаажуулсан ажил байдлын тодорхойлолт;

4.6.4. Хамт олны хурлаар хэлэлцсэн тэмдэглэл;

4.6.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг;

4.7. Шагналыг тэмдэглэлт баяр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Барилга, хот байгуулалтын яамны шагналын цахим бүртгэлийн систем /www.reward.mcad.gov.mn/-д баталгаажсан хэрэглэгчийн эрхээрээ үнэн, зөв бүртгүүлсэн байна.

4.8. Шагналын цахим бүртгэлийн систем нь тухайн баяр, тэмдэглэлт өдөр болохоос 90 хоногийн өмнө нээгдэж, 30 хоногийн өмнө хаагдах ба энэ хугацаанд хүсэлт гаргагч байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан цахим бүртгэлийн системд хандаж 4.6-д заасан мэдээллийг бүрэн оруулсан байна.

4.9. Программын серверийн үйл ажиллагаа зогсох, гэмтэл гарах, гадны халдлагад өртөх, хандалт хийх боломжгүй болох, хэт ачааллаас болж гацах зэрэг техникийн сааталтай үед шагналын материалыг цаасан суурьтай хүлээн авч болно.

4.10. Шагналд нэр дэвшигчийн холбогдох мэдээллийг цахим бүртгэлийн системд хуурамчаар бүртгүүлж, бүрдүүлсэн нь нотлогдвол тухайн байгууллагын эрхийг 1 жилээр хязгаарлаж, шагнал олгохгүй.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Шагналыг дараах нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан олгоно. Үүнд:

5.1.1. Үндэсний их баяр наадам;

5.1.2. Шинэ жил;

5.1.3. Салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр буюу Барилгын салбар үүсч хөгжсөний баярын өдөр, Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний баярын өдөр, Газрын харилцааны салбар үүсч хөгжсөний баярын өдөр;

5.2. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг”-ийг байгууллагын ой болон насны ойг тохиолдуулан олгохгүй.

5.3. Төрийн захиргааны удирдлагын газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн цахимаар шагналын материалыг хүлээн авч хянаж, яамны удирдлагад танилцуулна.

5.4. Төрийн захиргааны удирдлагын газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагналд тодорхойлсон хүсэлтийг хүлээн авч энэхүү журамд заасан үзүүлэлт, шаардлагыг хангасан ажилтныг шагнах тухай шийдвэрийн төсөл боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар олгоно.

5.5. Хувийн дугаар бүхий “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан”-ны үнэмлэх болон яамны “Жуух бичиг” дээр зөвхөн Засгийн газрын гишүүн, сайд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.6. Шагналыг тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

5.7. Шагнагдсан ажилтны нэгдсэн бүртгэлийг яамны архивт хүлээлгэж өгнө.

Зургаа. Хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн болон сольж олгох

6.1. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх болон яамны “Жуух бичиг”-ийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд нөхөн болон сольж олгож болох ба дараах баримт бичгийг бүрдүүлэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүсэлтээ гаргана:

6.1.1. Тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн нөхцөл шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл;

6.1.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;

6.1.3. Мөнгө тушаасан баримт.


6.2. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзээд, нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн олгоход 20,000 /хорин мянга/ төгрөг, “Жуух бичиг” нөхөн олгоход 15,000 /арван мянга/ төгрөгийн төлбөрийг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулсны дараа олгоно.

6.3. Хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн олгох төлбөрийг яамны харилцах дансанд төвлөрүүлнэ /Барилга, хот байгуулалтын яамны Төрийн банк 104900042858 тоот данс/.

-----o0o-----

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ШАГНАЛД
НЭР ДЭВШИГЧИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. Ургийн овог:
2. Эцэг/ эхийн нэр.....
3. Өөрийн нэр:.....
4. Нас, хүйс:
5. Регистрийн дугаар:
6. Төрсөн аймаг, сум, хот:
7. Хаяг, Утасны дугаар :
8. Ажилладаг салбар:
9. Мэргэжил:
10. Урьд болон одоо эрхэлж байгаа ажил /хүснэгтэд бичнэ/:



№	Ажилласан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Хугацаа (он, сар)	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			
4.			
5.			

11. Нийт ажилласан жил:, үүнээс тухайн салбарт ажилласан жил:

12. Шагнагдсан шагналын нэр /салбарын шагналын нэрийг заавал бичнэ/

№	Шагналын нэр	Хэдэн онд
1.		
2.		
3.		
4.		
5.		

13. Шагнуулах үндэслэл: /Гаргасан амжилтыг товч тодорхой бичнэ/

.....

.....

.....

14. Шагнуулахаар нэр дэвшсэн шагналын нэр: /шагналын нэрийг зөв тодорхой бичнэ/

.....

.....

.....

15. Хамт олны саналын хувь:

16. Байгууллагын холбоо барих ажилтны нэр, утасны дугаар

БАТАЛГААЖУУЛСАН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГАРЫН ҮСЭГ

/ТАМГА ,ТЭМДЭГ, ОН САР ӨДӨР/